# МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН ДЭГ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дэг нь Мэдээлэл холбооны мэргэжлийн нэгдсэн холбоо (цаашид “МНХ” гэх)-ны бүх гишүүдийн хурал, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль болон МНХ-ны дүрмийн хүрээнд тогтооход оршино.

1.2 Энэхүү дэгийг МНХ-ны бүх гишүүдийн хурлын бүхий л үйл ажиллагаанд баримтална.

1.3 Энэхүү дэгд заасан дараах нэр томъёог доор дурдсан агуулгаар ойлгоно:

1.3.1 “**Бүх гишүүд**” гэж МНХ-г үүсгэн байгуулахаар нэгдсэн мэргэжлийн холбоодыг хамтад нь;

1.3.2 “**Бүх гишүүдийн хурлын төлөөлөгч**” гэж МНХ-г үүсгэн байгуулах хуралд оролцох эрх бүхий тухайн мэргэжлийн холбооноос томилогдож, мандат авсан хувь хүнийг;

1.3.3 “**Горимын санал**” гэж хурлаар тухайн асуудлыг хэрхэн хэлэлцэх, шийдвэрлэх талаар гишүүнээс гаргасан саналыг;

## Хоёр. Хурлын дараалал, Хурлын дарга, Тэргүүлэгчдийн эрх, үүрэг

2.1 Бүх гишүүдийн хурлыг гишүүд дотроос ил санал хураалтаар сонгогдсон 3-5 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй хурлын дарга, Тэргүүлэгчид удирдан зохион байгуулна. Сонгогдсон төлөөлөгчид дотроосоо хурал даргалагчаа сонгоно.

2.2 МНХ-ны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь хурлын дарга, Тэргүүлэгч байж болохгүй.

2.3 Хурлын дарга хурал эхэлснийг мэдэгдэж, дор дурдсан дарааллын дагуу хурлыг удирдан явуулна. Үүнд:

2.3.1 Гурван (3) төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй хурлын Тооллогын комиссыг томилох;

2.3.2 Шаардлагатай бол бүх гишүүдийн саналаар хурлын дэгд өөрчлөлт оруулах;

2.3.3 Хурлаар хэлэлцэх асуудлыг батлуулж, хэлэлцүүлэх;

2.3.4 Хэлэлцэх асуудал бүрээр тогтоол батлуулах;

2.3.5 Хэлэлцэх асуудал дууссаны дараа хурлыг өндөрлүүлэх.

2.4 Хурлын дарга, Тэргүүлэгчид нь дараах бүрэн эрхийг хурлын туршид хэрэгжүүлнэ. Үүнд:.

2.4.1 Хурлыг товлосон цагт эхлүүлж дэгийн дагуу зохион байгуулах.

2.4.2 Хэлэлцэх асуудлыг батлагдсан хөтөлбөр, дарааллын дагуу бүрэн хэлэлцүүлэх;.

2.4.3 Хэлэлцсэн асуудлаар санал хураалт явуулж, дүнг мэдээлж, эцсийн шийдвэрийг танилцуулж батлуулах;.

2.4.4 Хэлэлцэж буй асуудлаар гишүүдийн гаргасан горимын саналыг сонсож, нэг удаа санал хураалгах;

2.4.5 Хурлын дэгийн биелэлтэд хяналт тавьж, гишүүдээс энэ дэгийг сахихыг шаардах;

2.4.6 Саналаа ирүүлсэн дарааллыг баримтлан гишүүдэд үг хэлэх зөвшөөрөл олгох.

2.4.7 Хурлын дэг зөрчигчид хариуцлага ногдуулах.

**Гурав.Хуралдааны дэг, түүнийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

3.1 Хуралдааны дэгийг дараах байдлаар тогтооно. Үүнд:

3.1.1 Хурлын төлөөлөгч асуудал танилцуулах, асуулт асуух, хариулт өгөх, санал хэлэх байдлаар хуралдаанд үг хэлэх тухай ирүүлсэн саналыг дараалаар нь бүртгэн олонхын саналаар тасалж болно.

3.1.2 Дүрмийн танилцуулга, хэлэлцүүлгийг нэг (1) цаг 15 минутад багтаан дуусгана. Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн танилцуулга болон мөрийн хөтөлбөр таван (5) минутаас илүүгүй байна.

3.1.3 Хуралдааны үдийн завсарлагыг хорин (20) минутаар тогтооно.

3.1.4 Хурлын төлөөлөгчийн үг хэлэх, асуулт асуух, санал хэлэх хугацаа хоёр (2) минутаас илүүгүй байх ба нэмэлт нэг (1) минут олгож болно.

3.1.5 Хурлын төлөөлөгчийн асуултад хариулах хугацаа хоёр (2) минут байх ба нэмэлт хариулт, тайлбар өгөх хугацаа нэг (1) минутаас илүүгүй байна.

3.1.6 Хурлын төлөөлөгч нь үг хэлэхдээ өөрийн овог, нэр болон төлөөлж буй байгууллагын нэрийг заавал дурдана.

3.1.7 Хурлын төлөөлөгч нь үг хэлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд халдах, бүдүүлэг үг хэрэглэх, гүтгэх, гутаан доромжлох, бусдад саад болохыг хориглоно.

3.1.8 Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй болон нэгэнт шийдэгдсэн асуудалтай холбоотой зүйл ярихыг хориглоно.

3.1.9 Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн этгээдийг хуралдаанд оролцуулахыг хориглоно.

3.1.10 Тухайн хурлын төлөөлөгчөөр бүртгэгдээгүй этгээд хуралдаанд оролцох, санал өгөх эрхгүй бөгөөд хуралдааны удирдлагын зөвшөөрөлгүйгээр хуралдаанд үг хэлэхийг хориглоно.

3.1.11 Тодорхой асуудлаар шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд заасан төлөөлөгчийн үг хэлэх хугацааг тухайн хуралдааны даргалагч өөрчлөн тогтоож болно.

3.1.12 Бүх гишүүдийн хурлын үйл ажиллагааг сурвалжлах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл болон урилгаар оролцох зочдыг хуралдаанд оролцуулж болно

3.2 Хурлын төлөөлөгч нь дэг зөрчсөн, ёс бус үйлдэл гаргасан, бусдыг доромжилсон, тухайн хэлэлцэх асуудалтай холбогдолгүй зүйл ярьсан, хуралдааны үйл ажиллагаа болон бусдад саад болсон бол хуралдаан даргалагч дараах арга хэмжээг авч болно:

3.2.1 Дэг баримтлахыг нэр заан шаардах;

3.2.2 Сануулга өгөх;

3.2.3 Сануулга авсан төлөөлөгч дахин зөрчил гаргавал түүнийг хуралдаанд үг хэлэх эрхийг хасах;

3.2.4 Энэхүү дэгийн 3.2.1-3.2.3-т заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түүнийг хуралдаанаас гаргах.

3.3 Хуралдаан даргалагч, Тэргүүлэгчид хурлыг удирдахдаа Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хууль болон МНХ-ны дүрэм, энэ дэгийг зөрчих, хурлын төлөөлөгчийн эрхийг хязгаарлах, хурлаа удирдах чадамжгүй байгаа тохиолдолд хуралд оролцсон гишүүдийн саналаар шинээр томилж болно.

3.4 Хуралдааны хэлэлцэх асуудлыг тухайн өдөрт нь дуусгах боломжгүй бол хуралдааны хугацааг сунгах эсхүл дараа нь үргэлжүүлэн хэлэлцэх эсэхийг хуралдаанд оролцогчдын ердийн олонхын саналаар шийдвэрлэж болно.

**Дөрөв. Хурлын санал хураалт**

4.1 Хуралдаанаар батлагдсан хэлэлцэх асуудлыг шийдвэрлэхдээ санал хураалтыг илээр явуулах ба зохион байгуулалтын асуудлыг илээр эсхүл нууцаар явуулахыг тухай бүрд нь шийдвэрлэнэ.
4.2 Ил санал хураалт явуулахдаа зөвхөн “дэмжинэ” гэсэн томъёоллоор хурлын төлөөлөгч нэг бүрийг мандат өргүүлэн тоолох ба хуралд оролцсон төлөөлөгчдийн олонхын санал аваагүй бол уг асуудлыг дэмжээгүйд тооцно.
4.3 Нууц санал хураалт нь Тооллогын комиссын дарга гарын үсэг зурж, МНХ-ны тэмдэг дарж албажуулсан саналын хуудас дээрх “дэмжинэ”, “дэмжихгүй” гэсэн томъёоллын аль нэгийн өмнөх эсхүл өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн өмнөх эсхүл өөрийн сонгохыг хүссэн нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуйг будаж тэмдэглэн саналыг хайрцагт хийх байдлаар явагдана. Тооллогын комиссоос хурлын төлөөлөгч бүрийг нэрээр нь дуудан бүртгэж саналыг хуудсыг олгоно.
4.4 Хурлын ирцэд бүртгэгдсэн боловч санал хураалтад оролцоогүй төлөөлөгчдийг тухайн асуудлыг дэмжээгүйд тооцно.
4.5 Тухайн санал хураалтад албан ёсоор оролцохгүйгээ хурлын даргад мэдэгдсэн төлөөлөгчийн саналыг хасаж тооцно.
4.6 Нууц санал хураалтад санал өгсөн хуудас нь буруу тэмдэглэгээ хийгдсэн бол уг саналыг хүчингүй санал гэж үзэн хасаж тооцно.

**Тав.Хуралдаанаас шийдвэр гаргах**

5.1 Бүх гишүүдийн хурлын шийдвэр нь хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн ердийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.
5.2 Бүх гишүүдийн хурлын шийдвэрт хурлын дарга, Тэргүүлэгчид гарын үсэг зурна.

---oOo---